

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 10 дугаар сарын 23-ны “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД		
1	“20 минут хот”, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний талаарх ойлголт, сургалтыг зохион байгуулахад идэвхтэй оролцох.	Нийт байгууллагуудын удирдлагууд
2	Нийслэлийн 2025 оны төсвийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг дарга нартай уулзалт зохион байгуулах.	СТСХ
3	Үр дүнтэй ажилласан Төсвийн Ерөнхийлөн захирагч болон төсвийн менежерүүдэд урамшуулал олгодог байх эрх зүйн орчинг бүрдүүлэх.	ТЗУХ
4	2025 онд замын сангийн хөрөнгөөр хийгдэх авто замын ажлууд болон хорооллын дундах авто замын засвар, шинэчлэл хийх саналаа Замын хөгжлийн газарт хүргүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ
ХОТ, НИЙТИЙН АЖ АХУЙН АЖЛЫН ХҮРЭЭНД		
5	Хот тохижилтын авто машинуудыг холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгөх ажлыг шуурхай зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	Дүүргүүд цаашид хот тохижилтын аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах санал ирүүлж, дахин шинээр сонгон шалгаруулалт зохион байгуулах.	
7	Хот, нийтийн аж ахуйн байгууллагуудад байгаа давс, бодисын чанар стандартад хяналт шалгалт хийхтэй холбогдуулан давс, бодис нөөцлөх агуулах сав бэлтгэх, давс бодисын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах бэлтгэлийг сайтар хангах, нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хот тохижилтын машин техник хэрэгслийн бэлэн байдлыг сайтар хангуулж, засвар үйлчилгээг хийлгүүлэх.	
8	Дүүргийн хэмжээнд их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, нийт байгууллагууд
9	2025 онд хийгдэх үерийн ус зайлуулах шугам сүлжээ, шинээр хийгдэх авто замуудад усны хаялага зэргийг хийхэд шаардлагатай зардлын тооцоо, судалгааг боловсруулж, танилцуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, ОБХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	Эрүүл мэндийн төвийн сувиллын зориулалтаар засварлаж буй байр руу бохирын шугам татах	Дүүргийн менежер Г.Дагвадорж, УСАТ, ЭМТ

	ажлыг яаралтай гүйцэтгэх.	
11	Нийслэл хотын 385 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтад анхаарах.	НХХ, нийт байгууллагууд
12	“Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд байгуулагдсан гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх.	ЗДТГ, нийт байгууллагууд
13	Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, СТСХ, ХААА
14	2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдах 2024 оны 2-р ээлжийн цэрэг татлагын ажлын бэлтгэлийг ханган үр дүнтэй зохион байгуулах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, Цэргийн штаб, Хороод, Ажлын хэсэг
15	2024-2025 оны дүүргийн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах хүрээнд өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.	ОБХ, нийт байгууллагууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР